



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
РАШААНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/42

Рашаант сум

**Эзэмшил газрын талбайн хэмжээ
өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.5 дахь заалт, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7 дахь заалт, 31 дүгээр зүйлийн 31.2 дахь заалт, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх заалт, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 15-ний өдрийн “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” А/133 дугаар тушаалын 8.9.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын иргэн Бадамдорж овогтой Мөнхтөрийн хүсэлтийн дагуу Цэнгэл багийн Сандил-8-805 байршилтай 6706003024 нэгж талбарын дугаартай Шатах, тослох материал түгээгүүрийн газар, агуулах, ШТС зориулалттай газрыг 2021 оны 04 дугаар сарын 01-ний өдрийн А/34 дугаар захирамжаар 900 м² гэж гаргасан шийдвэрийг өөрчлөн 2968 м² болгон үлдсэн 12 жилийн хугацаатайгаар өөрчлөн эзэмшүүлсүгэй.

2.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 04 дугаар сарын 01-ний өдрийн А/34 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

3.Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэдтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамалд зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн биелэлтэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Т.Отгонцэцэг)-д, байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (М.Билэгдэмбэрэл) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Б.АЛТАНГЭРЭЛ

D:\nasaa bichig hereg\A-Zax.doc

6706011072